

# Рицуимейкан Ази Номхон Далайн Их Сургууль

БАКАЛАВРЫН ЗЭРГИЙН ХӨТӨЛБӨР

АНДС (Ази, Номхон далай судлал)

АНДМ (Ази, Номхон далайн менежмент)


МАГИСТР, ДОКТОРЫН ЗЭРГИЙН ХӨТӨЛБӨР

МВА (Бизнесийн удирдлага)

ОУХАБ (Олон улсын хамтын ажиллагааны бодлого)

АНДС (Ази, Номхон далай судлал)

## LIGHT UP THE WORLD



立命館アジア太平洋大学

**APU**

Ritsumeikan Asia Pacific University

## Азийн сод билэгт залуусыг урьж байна

АНДИС нь шинэлэг сургалтын систем болон багш, оюутны бүрэлдхүүн олон үндэстнээс бүрдсэн байдгаараа Японы хамгийн шинэлэг их сургуулийн нэг болсон билээ. Өнөөдөр дэлхийн зах зээл дээр бусад улс орон, соёлын талаархи мэдлэг зайлшгүй шаардагдаж байна. АНДИС дээр та дэлхийн 70 гаруй орноос ирсэн оюутнуудтай харилцах болно. Ийм орчин нь гадаад харилцааны чадварыг хөгжүүлж, бусад орны соёлын тухай ойлголт өгч чадна. Төгсөгчдийн 90 гаруй хувь нь Японы корпораци, байгууллагуудаас ажлын санал авдаг тус их сургууль Азийн сод билэгт залуучуудаар дэлхийн өртөнцийг гийгүүлж байна.

Дэлхийн эдийн засаг Ази Номхон далайн бус нутагтай бүх талаараа холбоотой болжээ. Улсын болон хувийн хэвшлийнхэн аль аль нь тогтвортой ёсөлтийг хангах гол хүчин зүйл бол мэдлэг боловсрол, ажлын туршлагатай мэргэжилтнүүд гэдгийг хүлээн зөвшөөрдөг. АНДИС-ийн оюутнууд бизнес, нийгмийн шийдвэрт үр дүнтэй нөлөөлж чадах чухал албан тушаалуудад ажиллаж чадах итгэл төгс, чадварлаг боловсон хүчин болж төгсдөг. Та нар дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн шинэ үзэл санаагаар цэнэглэгдсэнээр дэлхийн тавцан дээр өрсөлдөхүйц үр дүнтэй бөгөөд үр ашигтай төлөвлөгөө зохиож чадах болно.





## Байршил

125,000 хүн амтай Бэлпу хэмээх жигж хотын сайхан үзэмж Рицуимейкан Ази Номхон Далайн Их Сургуулиас илхэн харагдана. Бэлпу нь Японы голын тогтолцоогоо хамгийн өмнө зүйт орших Кюшю хэмээх томоохон арлын зүүн хойд эрэг дээр боссон хот билээ. Тус хот нь халуун рашаан элбэгтэйгээрээ дэлхийд алдартай. 3000 гаруй рашаан булагаас ног өдөрт нийт 140,000 орчим тонн ус үндэслэгээрээ дэлхийд Америкийн Нэгдсэн Улсын Еллөөстөүний Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн дараа хоёрдугаарт ордог юм. Үзэсгэлэнт уулс болон ялалзан долгилох Бэлпу булангаар хүрээлэгдсэн хотын түүхт зам гудамж, тэнгэрт хөвөх цагаан үүлс нь түм тужигнэж бум буяжигласан Токиогийн их хөлөөс зайдуу, хуучны тайван сайхан хотын шинжийг илтгэнэ.

## Гадаад оюутнуудад үзүүлэх тусlamж дэмжлэг

АНДИС нь гадаад оюутнууддаа шинэ газар, шинэ орчиндоо дасах төвхнөхөд нь олон талын тусlamж дэмжлэг үзүүлдэг. Танилцуулга, удирдамж өгөх хичээл явуулах, оюутны хотходн өдөр тутмын үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү тусlamж дэмжлэг, явуулж буй үйл ажиллагааны маань гол зорилго нь оюутнууд амьдралын хэв маягийн өөрчлөлтөнд хурдан дасан зохицож, Япон орноос сурч мэдэх зүйлээ аль болох бүрэн хэмжээгээр нь мэдэж авахад нь туслахад оршино.



## Ази-Номхон далайн оюутны байр

Олон үндэстэн ястанаас бүрдсэн оршин суугчидтай энэхүү байранд АНДИС-ийн хэдэн зуун гадаадын болон япон оюутнууд амьдардаг. Гадаадын оюутнууд АНДИС-д элссанийээз дараа доод тал нь нэг жилийн хугацаанд энэхүү байранд өрөө авдаг. Энэ оюутны байранд ор, ширээ, бис засах өрөө, угаалтуур, агааржуулагч бүхий нэг хүний тусгай өрөөнүүдтэй юм. Нийтийн гол тогго, хоолны танхим, шуршүүр давхар бүрт бий. Оршин суугчид нь мөн 24 цагийн компьютерийн өрөө, хоол, үндэсний автомат, уулзалтын өрөө, чийргүүлэх танхим зэргийг ашиглаж боломжтой. Шинээр элссэн гадаадын оюутнуудад зөвлөгөө, тусlamж үзүүлдэг оршин суугчдын туслах буюу ахлах курсын туршлагатай оюутнууд давхар бүрт байрлладаг бөгөөд АНДИС-д сурч амьдрах талаар ямар ч асуултанд хариулахад бэлэн байдаг. АНДИС-ийн хичээлийн ба номын сангийн байрнуудаас хэдхэн алхмын зайтай орших АНД-н оюутны байр нь Японд дөнгөж ирсэн гадаадын оюутнууд шинэ амьдралын эхлэх аюулгүй, тох тухтай орчныг бүрдүүлдэг.



## Мэдээллийн төв

Орчин үеийн мультимедиа тоног төхөөрөмж бүхий төв. Мэдээллийн төв нь бүх төрлийн мэдээлэл цуглуулж, солилцох төв юм. Энд номын сан, компьютерийн нарийн тоног төхөөрөмж, оюутнууд компьютерийн тусlamжтай (CAI) хэлний мэдлэгээ дээшлүүлэх анги танхим байдаг.

## Оюутны холбоо

Энэ байгууламж нь оюутнуудын хэрэгцээг хангах зориулалттай. Нэгдүгээр давхарт хоолын газар байрлахаас гадна хүнсний бүтээгдхүүн, одор тутмын хэрэглээний зүйл зардаг дэлгүүр байна. Хоёрдугаарт давхарт кафе, клубуудын хурлын танхим, япон үндэсний өрөө, хөгжмийн студи, мультимедиа лаборатори байрлана.

# Сурч Боловсрох

Өнөөдөр дэлхий ертөнцөд хил хязгаар, хэлний ялгаа арилж байгаа нь сурах шинэ боломж та бидэнд өгч байна. 70 гаруй улс орноос ирсэн багш оюутнууд их сургуулийн нийт багш оюутны 50 хувийг эзэлдэг. Та газар газраас ирсэн ийм оюутнуудтай хамт ажилласнаар багийн гишүүн, удирдагч байх талаар илүү сайн ойлголтой болж, дэлхийн аль ч оронд ажиллах бэлтгэлтэй болно. АНДИС-ийн оюутнуудад олон боломж бий. Тухайлбал:

**Дадлага.** Хэд хэдэн хичээлээр оюутнууд бодит асуудал шийдэж, мэдлэг чадвараа ирээдүйн ажил олгогчдод харуулах тесөлд оролцено.

**Семинар.** Улс төр, бизнесийн ертөнцийн томоохон зүтгэлтнүүдийг АНДИС-д урьж Ази Номхон далай болон дэлхий ертөнцийн тулгамдсан сэдвээр лекц үншуулдаг.

**Мэдээллийн технологи.** АНДИС оюутнуудад хэллэлцүүлгийн бүлэгт оролцож, унших материал татан авч, хийсэн ажлаа сүлжээнд оруулах, интернет сургалтад бүртгүүлэх боломж өгөхийн тулд хамгийн орчин үеийн технологийг идэвхтэй ашигладаг.

**Ажлын байр.** Гадаадын оюутнууд ажил хайхад хэцүү байдаг. АНДИС-ийн Ажил мэргэжлээ сонгоход туслах хөтөлбөр оюутнуудад дотоодын болон гадаадын шилдэг компаниудад ажил олоход нь тусалдаг.

Японы Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамнаас хоёр жил дараалан АНДИС-ийн өвөрмөц, дэвшилтэт сургалтын хөтөлбөрийг шалгаруулж “Сайн үлгэр жишээ” хэмээх шагнал олгосон.



## Хэлний сургалт

АНДИС-д элсэхэд япон хэлний мэдлэг заавал шаардагдахгүй.

Бакалаврын сургалт - Хос хэлний сургалтын тогтолцоо

- 1, 2 дугаар курсын оюутнууд англи, япон хэлний аль нэг дээр хичээл үзэхийн сацуу өөр нэг хэл сурна
- 3, 4 дүгээр курсын оюутнууд англи, япон хэлний аль нэг дээр хичээл үзнэ
- Ази Номхон далайн бусад хэлийг сурах: хятад, солонгос, малай/индонез, испани, тай, вьетнам
- Дээд шатны оюутнуудад зориулсан япон хэлний төрөлжсөн хичээл: аман орчуулга, япон хэл заах аргачлал, бизнесийн япон хэл гэх мэт.

Магистр, Докторын зэргийн сургалт - Япон хэл заавал шаардагдахгүй

- Магистр, докторын зэргийн сургалт англи хэл дээр явагдана: Элсэх буюу тэгсөхөд япон хэл шаардагдахгүй.
- Эрдмийн англи хэлний мэдлэгээ дээшлүүлэх хөтөлбөрүүд бий
- Сонирхсон оюутнуудад япон хэлний сонгон суралцах курс орно

## Сургалтын хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа

Бакалаврын хөтөлбөр – 4 жил

Магистрын хөтөлбөр – 2 жил

Докторын (PhD) хөтөлбөр – 3 жил

Түргэвчилсэн сургалтын хөтөлбөрүүд бий.

АНДИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрт кредитээ шилжүүлэх боломжтой – өөр их сургуульд авсан кредитээ АНДИС дээр тооцуулж болно. Оюутнууд 2 дугаар курсээсээ (гурван жил суралцаж тэгсөнө) буюу 3 дугаар курсээсээ (хоёр жил суралцаж тэгсөнө) шилжин ирж болно.

## Ажил мэргэжлээ сонгоход туслах хөтөлбөр

АНДИС оюутнуудад зорьсон чиглэлээрээ цаашид ажиллах, төгссөнийхөө дараа ажилд ороход нь туслалцаа үзүүлдэг.

**Бүрэн дэмжлэг туслалцаа.** Ажил мэргэжлээ сонгоход туслах хөтөлбөр нэгдүгээр курсээс эхэлдэг бегөөд зорилгодоо алхам алхмаар хүрдэг.

**АНДИС-ийн ажил мэргэжлийн алба.** Оюутан бүрийн мэргэжлийн сонголт, зорилгод таарах дэмжлэг туслалцаа үзүүлдэг.

**Ажилд орох.** Сүүлийн хоёр жилийн хугацаанд бакалаврын сургалт дүүргэсэн гадаадын оюутнуудын 90 гаруй хувь нь ажилын байртай болж чадсан.



## Бакалаврын сургалтын чиглэлүүд

### АНДС Ази Номхон далай судлал Нийгмийн ухааны бакалавр

АНДС-ын хичээл нь олон улсын харилцаа, олон улсын социологи, бус нутгийн судлал гэсэн сэдвүүд дээр үндэслэсэн. Оюутнууд улс хоорондын "хүн, бараа, мөнгө, мэдээллийн" хөдөлгөөн дэлхийний нийт, түүний дотор Ази Номхон далайн бус нутагт ямар нелөө үзүүлж байгааг судална. Оюутнууд манай гариг өртөнцөд тулгарч байгаа хөгжил, олон улсын хамтын ажиллагаа, зөрчил мөргөлдөөнийг шийдвэрлэх зэрэг зүйлтэй холбоотой янз бүрийн асуудлаас сонгож гүнзгийрүүлэн судалж болно. Тус хөтөлбөр нь Ази Номхон далайн бус нутгийн чухал асуудлаар мэдлэгтэй сэтгүүлчид, олон улсын төрийн албан хаагчид, төрийн бус ба ашгийн бус байгууллагын ажилтнууд, янз бүрийн салбарын судлаач зэрэг олон улсын хэмжээнд ажиллаж чадах мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилготой.

### ШИНЭ: Гүнзгийрүүлсэн холимог хөтөлбөр

АНДИС бакалаврын хоёр коллежийг холбосон олон сургалтын хөтөлбөрийг хамарсан Гүнзгийрүүлсэн холимог хөтөлбөр бий болгоно. Энэ хөтөлбөрийг сонгосон оюутнууд Ази Номхон далай судлал буюу Ази Номхон далайн менежментийн хөтөлбөрийн аль нэгэнд элсэж, янз бүрийн хөтөлбөрт орсон гүнзгийрүүлсэн шатны, өөр мэргэжлийн хичээлүүд үзэх боломжтой. Бий болгохоор төлөвлөж байгаа хөтөлбөрүүд (бүх нэрийг урьдчилсан байдлаар гаргав):

- Жуулчлал, өв, зочид буудлын менежмент
- Байгаль орчны загвар, хүний экологи
- Олон улсын стратеги судлал
- Мэдээлэл холбооны технологи
- Хэл соёл судлал

### АНДМ Ази Номхон далайн менежмент Бизнесийн удирдлагын бакалавр

АНДМ нь Ази Номхон далайн бус нутагт бизнесийн шинэ үнэт зүйл бий болгож чадах шинэ үеийн ажил хэрэгч хүмүүст дэлхийн хэмжээний цар хараа, асуудал шийдэх чадвар суулгах зорилготой. Корпорацийн менежментийн үндсэн ойлголтыг егөхийн тулд сургалт нь менежментийн үндсэн сэдвэтийн төвлөрөхийн зэрэгцээ маркетинг, корпорацийн стратеги, нягтлан бодох бүртгэл, санхүү, олон улсын бизнес, харьцуулсан менежмент зэрэг төрөлжсөн чиглэлүүдээр хичээл ордог. Сургалтын сэдвүүд нь Ази Номхон далайн бус нутагт хэрэгжүүлж болох корпорацийн менежментийн тэргүүлэх хандлагуудын талаар ойлголт өгөх зорилготой. Түүнчлэн гүнзгийрүүлэн төрөлжсөн сэдвүүд нь оюутан бүрт тодорхой сэдвээр гүнзгий мэдлэг олж авах боломж өгч байна. АНДМ хөтөлбөрийн оюутнууд үндсэн онолын мэдлэг олж авахын зэрэгцээ түүнийг хэрэгжүүлэх чадварт суралцдаг.




"АНДИС-д суралцах үед надад тохиолдсон хамгийн гайхамшигтай явдал гэвэл сургалтаа дүүргэж байх үедээ би дэлхийн гуравдах том мэдээллийн технологийн компани Фүжицүд ажилд орохоор болсон явдал билээ."

Сафван Хиндави, Арабын Бүгд Найрамдах Сири Улс

# Магистр, Докторын зэргийн сургалтууд

Технологийн дэвшилийн үр дунд Ази Номхон далайн бус нутаг түүхэнд анх удаа тодорхойлж болох нийгэм эдийн засгийн нэгж болж нягтарсан. Энэ зуунд дэлхий ертөнц энэ бус нутгийг анхааралтайгаар ажиглах болно. АНДИС-ийн бакалаврын дараах сургалтын хөтөлбөрт хамрагдаж байгаа оюутнууд өөрчлөлтийн тэргүүн эгнээнд байх боломжтой. АНДИС-ийн бакалаврын дараах сургалтыг дүүргэснээр таны оюуны мэлмий нээгдэж, дэлхий ертөнц болон түүний өгөх боломжийн талаархи бодол тань өөрчлөгднө. Манай хөтөлбөрүүд итгэл үнэмшлээ дахин эргэцүүлж, соёлын ялгааг давж гарах хүснэгтэй - дэлхий ертөнцийг зөрөг тал руу нь өөрчлөхийг хүсдэг хүмүүст зориулагдсан.

Тус сургалтын олон багш нар олон улсын тэргүүлэх байгууллагууд, олон улсын хамтын ажиллагаа, хөгжлийн улсын болон хувийн байгууллагууд, Японы тэргүүлэх корпорациудад томоохон албан тушаал хашдаг. Эдгээр багш нар мэргэжлийн нэр хүндтэй эрдэмтэн багш нартай хамтран ажиллаж оюутнуудад ирээдүйн ажил сургуульд нь хэрэг болох онолын баттай мэдлэг олгохоос гадна манай бус нутагт тулгараад байгаа бодит асуудлыг практикийн үүднээс шийдвэрлэх чадвар өгнө.



## АНДС/ОУХАБ

Ази Номхон далай судлалын сургууль

Мэргэшил - Ази Номхон далай судлал (АНДС)

- Ази Номхон далай судлалын магистрийн зэрэг
- Ази Номхон далай судлалын доктор (PhD)

Асуудал дээр суурилсан арга техник хэрэглэснээр оюутнууд бус нутгийн нийгэм, соёл, улс төрийн асуудлыг "Ази - дэлхийн тавцан" гэдэг хандлагаар судална.

Мэргэшил - Олон улсын хамтын ажиллагааны бодлого (ОУХАБ)

• Олон улсын хамтын ажиллагааны бодлогын магистрийн зэрэг Ази Номхон Далайн бус нутаг дахь олон улсын хамтын ажиллагааны янз бүрийн чиглэлээр өндөр түвшний ур чадвартай болохыг хүссэн хүмүүст зориулсан мэргэжлийн сургалтын хөтөлбөр. Оюутнууд дараах дөрвөн чиглэлээс сонгон авч болно: Олон улсын төрийн удирдлага, байгаль орчны бодлого, удирдлага, жуулчлалын бодлого, удирдлага, хөгжих буй орны эдийн засаг.



"Ангид уу, ангис гадуур уу, клуб дээр үү, оюутны байранд уу яг хаана хэзээ энэ тохиолдсоныг мэдэхгүй. Ямар ч байсан АНДИС өөрийгөө болон зорилгоо харах миний бодлыг өөрчилсөн билээ."

Май Ядана Аунг, Мьянмар

## МВА

Менежментийн сургууль (МВА)

Бизнесийн удирдлагын магистр (МВА)

- Санхүү, олон улсын бизнес, маркетинг, шинэчлэл, технологийн менежмент зэрэг сэдэвийг голлон үзнэ. Саяхныг болтол олон хүн чанартай МВА буюу бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрт суралцах тулд АНУ-ын их сургуулиудад суралцах ёстой гэж боддог байлаа. АНДИС-ийн Менежментийн сургууль АНУ-ын сургуулиудтай дүйцэх чанартай сургалтыг Японд явуулдаг бөгөөд Азийн бизнесийг голлон үздэг онцлогтой. Тус сургуулийн сургалт нь Хойд Америкийн бизнесийн тэргүүлэх сургуулиудад хэрэглэдэг концепц, аргачлал дээр үндэслэсэн бөгөөд Япон болон Ази Номхон далайн бусад оронтой холбоотой жишээтэй хослуулсан юм. Хичээл өөр өөр соёлтой орны хүмүүсийн орчинд зөвхөн англи хэлээр явагдана. Ингэснээр оюутнууд бусдаасаа туршлага судалж, олон улсын бизнест амжилттай ажиллахад шаардагддаг чадвар, мэдрэмжийг эзэмших боломжтой.

# АНДИС-д ЭЛСЭХ

Дараах мэдээллийг Японоос гадна оршин суугч япон биш өргөдөл гаргагчдад зориулав. Бусад бүх өргөдөл гаргагчид элсэлттэй холбоотой мэдээлэл авъя гэвэл АНДИС-ийн Элсэлтийн албатай холбоо барина уу. Энд тавих шаардлагыг товчхон оруулсан: бүрэн зөв мэдээлэл авъя гэвэл Элсэлтийн зааврыг харна уу (танд хэвлэмэл хувь хэрэгтэй бол холбоо барина уу) эсвэл манай вэбсайтыг үзнэ үү: <http://www.apu.ac.jp/admissions>.

## 1. Элсэлтийн үндсэн шаардлага

**Бакалаврын сургалтын хөтөлбөр:** Нэгдүгээр курсын оюутнаар элсэхийн тулд та зарчмын хувьд албан ёсны 12 жилийн боловсрол эзэмшсэн байх ёстай. Хоёр, гуравдугаар курсээсээ шилжин ирч байгаа бол дээрх шаардлага 13, 14 жил тус тус болно. Мөн англи, япон хэлний аль нэгийг лекц ойлгох хэмжээнд эзэмшсэн гэдгээ нотлох ёстай.

**Магистрын сургалтын хөтөлбөр:** Зарчмын хувьд та хүлээн зөвшөөрөгдсөн их сургуулиас ердийн бакалаврын зэрэг авсан байх ёстай бөгөөд бие даасан судалгаа хийж, задлан шинжилсэн эссе бичих хэмжээнд англи хэлийг эзэмшсэн байх ёстай.

**Докторын сургалтын хөтөлбөр:** Точ намтар, судалгааны саналаа Элсэлтийн албанад танилцуулахаар өгч тусгай зөвлөгөө авна уу.



## 2. Өргөдөл гаргах

Та дараах арга замаар өргөдөл гаргаж болно:

- Интернетээр: дэлгэрэнгүй мэдээллийг АНДИС-ийн вэбсайтанд орж үзнэ үү ([www.apu.ac.jp/admissions](http://www.apu.ac.jp/admissions)).
- Цаасаар: танд өргөдлийн багц материал байхгүй бол АНДИС -тай холбоо барина уу.

Өргөдлийг жилийн турш хэзээ ч гаргаж болно. Та элсэлтийн тохиromжтой хугацаанд бүртгүүлэхийн тулд өргөдлөө дараах сар өдрөөс өмнө АНДИС-д хүргэсэн байх ёстай:

- Хаврын (Дөрөвдүгээр сарын) элсэлт: өмнөх жилийн 9 дүгээр сарын 30 (бакалаврын дараах сургалтанд элсэх өргөдлийн тухайд 10 дугаар сарын 31)
- Намрын (Есдүгээр сарын) элсэлт: тухайн жилийн 3 дугаар сарын 31 (бакалаврын дараах сургалтанд элсэх өргөдлийн тухайд 4 дүгээр сарын 30)

## 3. Шалгах

Өргөдөл хавсаргасан бүх бичиг баримтыг шалгана. Зарим тохиолдолд тантай ярилцлага хийхийг хүсч болно. Хэрэв таны өргөдөл нааштай шийдэгдэвэл өргөдөл хүлээн авснаас хойш хоёр сарын дотор хүлээн авсан тухай болон олгосон тэтгэлгийн тухай мэдэгдэл авна.

## 4. Виз авах ба элсэх


Та АНДИС-д элсэх хүсэлтэйгээ баталж, шаардагдах хураамжийг төлсөн бол АНДИС амжилттай өргөдөл гаргагчдын өмнөөс Японд суралцах виз авах шаардлагыг хангасан тухай гэрчилгээ авахаар өргөдөл гаргана. Та дараа нь суралцах виз авах шаардлагыг хангасан тухай гэрчилгээгээ өөрийн орон дахь Японы Элчин сайдын яам, консулын газарт өгч виз авна. Визээ авсан бол та одоо Япон явахад бэлэн боллоо!

## 5. Төлбөр, хураамж

Дараах зардлууд барагцаалсан тооцоо бөгөөд 2005 оны хичээлийн жилийн төлбөр хураамж дээр үндэслэсэн. Америк долларт шилжүүлэх ханшийг 100 иен = 0.95 АНУ доллар гэж тооцсон. Төлбөр хураамжийн талаар илүү нарийн мэдээлэл авъя гэвэл Элсэлтийн зааврыг унших буюу АНДИС-ийн вэбсайтыг үзэж, валют арилжааны ханшийн мэдээлэлтэй тулгах ёстай.

**Нэг удаагийн элсэлтийн хураамж:** 100,000 япон иен (ойролцоогоор 950 ам.доллар)

**Бакалаврын сургалтын төлбөр:** 1,250,000 орчим япон иен (ойролцоогоор 11,875 ам.доллар)



**Магистр, Докторын зэргийн сургалтын (АНДС/ОУХАБ) төлбөр:** 1,400,000 орчим япон иен (ойролцоогоор 13,300 ам.доллар)

**Бакалаврын дараах сургалтын (МВА) төлбөр:** 1,800,000 орчим япон иен (ойролцоогоор 17,100 ам.доллар)

**Амьжиргааны зардал:** Та байр, хоол, бусад зүйлд нэг жилд 1,000,000 орчим япон иен (9,500 ам.доллар) зарцуулахаар тооцох хэрэгтэй.

## 6. Сургалтын тэтгэлэг

АНДИС тэнцсэн өргөдөл гаргагчдад дараах тэтгэлгийг олгоно. Элсэлтийн материалыг шалгах явцдаа мөн тэтгэлэгт тэнцэх эсэхийг нь давхар шалгадаг: тиймээс тусгай өргөдөл гаргах шаардлагагүй.

**Сургалтын төлбөрийг хөнгөлөх:** Бакалаврын сургалтанд элссэн оюутны сургалтын ердийн төлбөрөөс 30, 65, 100 хувь хөнгөлнө. Бакалаврын дараах сургалтад хамрагдсан оюутнуудын хувьд 20%, 50%, 70%, 100% хөнгөлнө.

**Амьжиргааны зардал:** Зөвхөн цөөн шилдэг өргөдөл гаргагчдад олгоно. Хоол унданд зарцуулж болох уг тэтгэлгийн хэмжээ нь нэг жилд 500,000, 1,000,000 иен үеөөд бэлнээр олгодог.

## Гадаад улс орнууд дахь АНДИС-ийн төлөөлөгчийн газрууд

Дараах улс орнуудад АНДИС-ийн төлөөлөгчийн газрууд байдаг.

Танай оронд манай төлөөлөгчийн газар байдаг бол тэндээс юм асууж лавлах хэрэгтэй.

Бусад орны оюутнууд доорхи хаягаар АНДИС-ийн Элсэлтийн албатай шууд холбоо барих хэрэгтэй.

### Canada

The UBC-Ritsumeikan Academic Exchange Program at University of British Columbia  
Room 333, Ritsumeikan-UBC House,  
6460 Agronomy Road, Vancouver, B.C. V6T 1W9, Canada  
Tel: +1-604-822-9501 Fax: +1-604-822-9515.  
URL: <http://www.ritslab.ubc.ca/>

### China

Ritsumeikan Liaison Office located in Shanghai Jiao Tong University  
Address: D.18F Suntong Infoport Plaza, No.55, Huaihai West Rd., Shanghai City,  
200030 China.  
Tel: +86-21-6283-5104 Fax: +86-21-6283-5247  
E-mail: [shanghai@st.ritsumei.ac.jp](mailto:shanghai@st.ritsumei.ac.jp)

### Indonesia

APU Office of Indonesia  
Address: Summitmas Tower I, 10th Floor Jl. Jend. Sudirman KAV. 61-62.  
Jakarta 12190, Indonesia  
Tel: +62-21-252-3708/3709 Fax: +62-21-252-3710  
E-mail: [univrap@pacific.net.id](mailto:univrap@pacific.net.id)

### Korea

APU Office of Korea  
Address: #505, Halla Classic Officetel 5th Floor, 824-11  
Yeoksam-Dong, Kangnam-gu, Seoul, 135-080, Korea  
Tel: +82-2-564-3425/3426 Fax: +82-2-564-3427  
E-mail: [hello@ritsapu-kr.com](mailto:hello@ritsapu-kr.com)  
URL: <http://www.ritsapu-kr.com>

### Taiwan

APU Office of Taiwan  
Address: 7F-5.6, No. 46; Sec. 2, Jhongshan N. Road,  
Taipei City 104, Taiwan (R.O.C.)  
Tel: +886-2-2523-6852, Fax: +886-2-2523-3910  
E-mail: [taipei@apu.ac.jp](mailto:taipei@apu.ac.jp)

### Thailand

Dr. Twee Hormchong,  
Visiting Prof. of Ritsumeikan Center for Asia Pacific Studies  
Address: 99/14 Soi 84 Petkasem Road, Bangkok 10160, Thailand  
Tel/Fax: +66-2-413-0275  
E-mail: [twee@apu.ac.jp](mailto:twee@apu.ac.jp)

Хиймэл дагуулаас авсан дэлхийн шөнийн байдлын гэрэл зураг.  
НАСА-гийн зөвшөөрөлтэй хэвлэв.



Ritsumeikan Asia Pacific University

### Admissions Office, Ritsumeikan Asia Pacific University

ADDRESS: 1-1 Jumonjibaru, Beppu, Oita 874-8577, Japan

TELEPHONE: +81 (Japan)-977-78-1119 FAXSIMILE: +81 (Japan)-977-78-1121

URL: <http://www.apu.ac.jp> / admissions

E-mail: [welcome@apu.ac.jp](mailto:welcome@apu.ac.jp)

